



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙХАН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 07 өдөр

Дугаар А/30

Онги

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 дүгээр зүйлийн 59.1.13, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2, 17.2.1 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.3 дахь заалт, Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 3.5.3, 3.5.13, 3.6.16 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн нутаг дэвсгэрийн хүчтэй, нэн хүчтэй доройтсон хөрсийг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр чадавхыг бэхжүүлэх зорилгоор “Дундговио ногооруулъя” хөтөлбөрийн хүрээнд “Эх дэлхийгээ аваръя жиргээ холбоо” НҮТББ-тай байгуулсан гэрээний дагуу уур амьсгалын өөрчлөлт цөлжилтийг сааруулах сургалт, зөвлөх үйлчилгээ, томилолтын зардалд, зарцуулах хөрөнгийг байгаль хамгаалах сангаас гарган зарцуулсугай.
2. Хамрагдах албан хаагчид, иргэний нэрсийг хавсралтаар баталсугай.
3. Орон нутгийн хүчтэй, нэн хүчтэй доройтсон хөрсийг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр чадавхыг бэхжүүлэх сургалт, зөвлөх үйлчилгээ, томилолтын зардалд 5,000,000 (таван сая) төгрөгийг байгаль орчныг хамгаалах сангаас гаргахыг нягтлан бодогч (Э.Наранцэцэг)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Г. ЛУВСАНРАГВА

Сумын Засаг даргын
2023 оны 07 дугаар сарын 07-ны
өдрийн А/30 захирамжийн хавсралт

Иргэдийн нэрс

№	Овог нэр	Регистрийн дугаар	Мөнгөн дүн
1	С.Болоржаргал	ЗЛ83041706	2,000,000 төг
2	Ц.Тунгалаг	ЗЛ84091805	2,000,000 төг
3	Э.Баатарчулуун	ЗЛ81042031	1,000,000 төг